

зохих байгууллага гаргах болно.

Арван есдүгээр зүйл

1. Томилсон улсын иргэдийн төрөлт ба нас барсан тухай актыг улсынхаа хууль зүйд зохицуулан уйлдэх эрхийг консул эдлэнэ.
2. Консул нь өөрийн иргэдийн төрөлт ба нас баралтын тухай суугаа орны зохих байгууллагат мэдэгдэж байна.

Хорьдугаар зүйл

Консул томилсон улсынхаа хууль зүй ёсоор өөрийн орны иргэд ба тэдний эд хөрөнгийг хамгаалах зорилгоор асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарыг томилж тэдэнд бүрэн эрхийг олгож болох бөгөөд ийм уед эдгээр хумуусийн уйл ажиллагааг консул хянаж байх эрхтэй болно.

Хорин нэгдүгээр зүйл

1. Консул нь томилсон улсын нисэх онгоцонд бух талын туслалцаа узуулэх эрхтэй. Хэрэв онгоцыг албадан буулгах бол онгоцны экипаж ба зорчигчдоос суугаа орны холбогдох байгууллагуудтай харилцахад нь тусламж дэмжлэг узуулэх ба нислэгийг цаашид ургэлжлүүлэх талаар зохих арга хэмжээ авна.

2. Консул нь хэрэв томилсон улсын онгоцонд осол гэмтэл тохиолдвол экипаж, зорчигчдод тусламж узуулэх, ачаа тээшийг аврах ба онгоцонд засвар хийх талаар арга хэмжээ авах буюу суугаа орны холбогдох байгууллагуудад хусэлт тавих эрхтэй.

•3. Золгүй тохиолдол буюу онгоцны осол гэмтлийн уед харилцан туслалцаа узуулэх тухай бусад хэлэлцээрт заагддаг тул энэ зүйлд дурдахгүй.

Хорин хоёрдугаар зүйл

1. Энэ гэрээнд заасан консулын эрх, уургууд нь консулын уурэг гүйцэтгэж байгаа дипломат төлөөлөгчдийн газрыш ажилтан нарт нэгэн адил хамаарагдана. Дипломат төлөөлөгчдийн газрын ажилтан нар консулын уургийг ингэж гүйцэтгэх нь тэдний дипломат эрх ямбанд ул харшилна.